

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	Нэр Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Сартуул овгийн Дагвын Цэнд-Аюуш
2	Хүсэлт гаргагчийн хаяг Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	Төрсөн огноо Төрсөн газар	
4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	МУИС-ийн хуулийн ангийг 1976-1981 он 1981.7.1-нд эрхзүйч-хууль цолтой. Диплом № 27693
5	Ажил эрхлэлт Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	-2010-2020 он ХЗДХЯ-ын ХЗТТөвийн Багануур салбарын ахлах улсын өмгөөлөгч -2007-2010 он Хууль хүний эрх төвийн гүйцэтгэх захирлаар, -2000-2007 он Хүний эрх хөгжил төвд хуульч судлаач, -1995 оноос хойш өмгөөлөгч -1993-1995 Бөөний худалдааний нэгдэлд хуулийн зөвлөх, -1989- 1993 он Ажилчны раойны Шүүхийн хяналтын тусалх прокурор, -1988-1989 он Октябрь раойны Прокурорын газарт Ерөнхий хяналтын туслах прокурор, -1981-1988 онд Улсын Прокурорын газрын Ерөнхий хяналтын хэлтэст прокурор,
6	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд

7	<p>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. 	<p>2014-2 сараас 2020- 5 сар Хууль Зүйн Туслалцааны Төвийн Багануур салбарын ахлах улсын өмгөөлөгч</p> <p>2010 оны 8 сараа 2014 оны 2 сар хүртэл Эрхзүйн Туслалцааны Төвийн өмгөөлөгч</p> <p>2000-2010 онуудад ТББ-ын өмгөөлөгч судлаачаар ажиллаж байсан.</p>
8	<p>Ёс зүй Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> -сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; -сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх. 	<p>Ямар ч байгууллагад ажиллаж байхдаа сахилгын шийтгэл хүлээж байгаагүй.</p> <p>Ямар нэгэн намд гишүүнээр элсэж байгаагүй.</p>
9	<p>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих 	<p>ХЗТТ-ийн Багануур салбарт ажиллахдаа төлбөрийн чадваргүй 297 иргэнд өмгөөгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна. Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4-р зүйлийг хэрэглэхгүй гэм буруугүй 3 иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй шүүхийн практикийг өөрчлөхийг зорьж бүх шатны шүүхээр тухайн хэргүүдийг хэлэлцүүлэн хэргийг цагаатгуулж байсан.</p> <p>-2020.2.12-ны өдрийн Улсын Дээд Шүүхийн 91 тоот тогтоол, -2019.5.31- өдрийн Улсын Дээд Шүүхийн 238 тоот тогтоол, 2015.9.16ны өдрийн Улсын Дээд шүүхийн 253 тоот тогтоолын хэргийг тус тус цагаатгуулж байв.</p>

	<p>мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	
10	<p>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</p>	<p>2014-2020 он ХЗДХЯ-ны Хууль зүйн туслалцааны Төвийн Багануур салбарт 6 жил</p> <p>2007-2010 Хууль хүний эрх төв 3 жил Гүйцэтгэх захирал</p> <p>2000-2007 он Хүний эрх хөгжил төв 7 жил</p> <p>1997-2000 Хуульч эмэгтэйчүүдийн Холбооны сайн дурын ажилтан.</p>
11	<p>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</p>	<p>Хүний эрх хөгжил төв ТББ-д судлаач-өмгөөлөгчөөр 7 жил ажиллахдаа.</p> <ol style="list-style-type: none"> 2000-2001 онуудад Эрүү шүүлтнээс ангид байх эрхийн хүрээнд “ЦАГДАН ХОРИХ БАЙРАН ДАХЬ ХҮНИЙ ЭРХ” мониторингийг Дорнод, Ховд, Төв аймгууд болон хорих 461-р ангуудад 2 удаа хийгдсэн. Энэ мониторинг хийгдсэнээр цагдан хорих байранд иргэдийн хяналт хэрэгтэй бөгөөд эрүүдэн шүүхээс ангид мөрдөн шалгах ажиллагааг нотлох баримтанд тулгуурлан шийдвэрлэх хандлага нээгдсэн. Энэ цаг үед Цагдан хорих байр Цагдаагийн хяналтаас гарч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хяналтанд очсон болно. Эмэгтэйчүүдийн эрхийг хүндэлж дээдэлдэг хүрээнд 2001-2007 онуудад Хүний наймаанд өртсөн 2 охиныг эх оронд нь буцаах болон гэмт хэрэгтэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үйл ажилд хохирогчийн өмгөөлөгчөөр шүүн таслах ажиллагаанд оролцож байв. <p>Энэ ажлын хүрээнд гэмт хэрэгтэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж чадсан. Улмаар 2002 оны Эрүүгийн хуульд ХҮН ХУДАЛДАХЫГ ГЭМТ ХЭРЭГТ тооцохоор болсон. Энэ заалт шинэ тутам</p>

	<p>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	<p>байсан тул УДШ-ийн бүгд хурлын тайлбар гаргуулахаар нөлөөллийн ажил хийж УДШ-ийн бүгд хурлын тогтоолоор Хүн худалдах гэмт хэргийн талаар тайлбар гаргуулж байсан. Энэ ажлын үр дүн нь бөгөөд нэг хүний эрхийн зөрчлийг шүүхээр хэлэлцүүлэх замаар шүүхийн практик болон хууль тогтоомжийг өөрчилж болохыг харуулсан өмгөөлөл болсон. Монголд анх удаа нөлөөллийн (стратегийн) өмгөөлөл хийх эхлэл болсон.</p> <p>3. Байгаль орчин ба хүний эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд Байгаль орчны “АРИУНСУВРАГА” иргэдийн хөдөлгөөнийн гомдлыг шүүхээр хэлэлцүүлэхээр стратигийн өмгөөллийг Архангай аймгийн Цэнхэр сумын “Нарийн хамрын гол” гэх кейс дээр 2003-2007 онуудад нутгийн иргэдийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан.</p> <p>Үр дүн: Нутгийн иргэдийн шаардлагаар уул уурхайн компаний нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгч болдгыг иргэдэд харуулсан.</p> <p>Стратегийн өмгөөллийн өөр чухал зүйл бол Ашигт малтмалын тухай хуульд Хайгууллын болон Ашиглалтын лиценз авахдаа орон нутгаас нь зөвшөөрөл авч байх заалтыг оруулсан.</p> <p>Иргэдийг төлөөлөн иргэний нийгэмийн байгууллага буюу ТББ тусгай зөвшөөрлөөр шүүхийн ажиллагаанд оролцох шаардлага байгааг гарган тавьсан. Хэдэн жилийн дараа хуулийн заалт бий болсон.</p> <p>4. Монголын төрийн бус байгууллагуудын форумын гишүүний хувиар ШУДРАГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН хүрээнд</p> <p>2008-2010 онуудад Хууль хүний эрх төвд ажиллаж байх хугацаанд 2008.7.1-ний өдрийн үймээн гэх үйл явдал болж тухайн үед онц байдал зарлагдаж олон залуус эрүүдэн шүүлтэнд өртөж хууль бус ажиллагаанууд явагдаж түүнд Монголын төрийн бус байгууллагын форумын гишүүд нэгдэж “ОНЦ БАЙДАЛ- ХҮНИЙ ЭРХИЙН МОНИТОРИНГ ХАМГААЛЛЫН” эвсэлийн багийн гишүүнээр ажилласан. “ДОЛООН САРЫН НЭГЭН” эвсэл байгуулагдсан бөгөөд эвслийн ерөнхий зохицуулагчаар ажиллаж тухайн үйл явцад мониторинг хийх иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулсан.</p> <p>Үр дүн: “7 сарын 1 буюу үймээн самууны хэрэг”хэмээн нэрлэгдсэн нэг гэмт хэрэгт 450 гаруй хүн сэжиглэгдэн шалгагдаж 300 *аад хүн яллагдагчаар татагдан, 270 иргэнийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 3,6-7 жилийн хорих ялаар шийтгэсэн юм. “ДОЛООН САРЫН НЭГЭН” эвсэл иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээг 148 иргэнд үзүүлж бүх шатын шүүхээр хэргийг хянуулсанаар эвслийн гишүүдээс үйлчилгээ авсан иргэд 3 жил 6 сарын ялаа 6 сарын хорих ялаар шийтгүүлж хорих ялын хугацааг буулгаж чадсан болно.</p>
12	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар</p> <p>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах</p>	<p>- Хууль Зүйн Туслалцааны Төвийн Багануур салбар БНД-ийн ЗДТГ-ын 102 тоот өрөө -6 жил</p>

	<p>мэдээллийг бичнэ: -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</p>	
13	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ. -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана. -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.</p>	<p>1995 оноос хойш Монголын Өмгөөлөгчдийн холбоо гишүүн болсон. 2014оноос Монголын Хуульчдын холбооны гишүүнд 2008 оноос Монголын төрийг бус байгууллагуудын форум"-ын гишүүнд 2007 Монфемнет Үндэсний Сүлжээ байгууллагын гишүүнд онд тус тус элсэж байсан.</p>
14	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл -Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг,</p>	<p>1.Хүний эрх хөгжил төвийн судлаач-өмгөөлөгчөөр ажиллаж байх хугацаандаа Соросын сан, Хүний эрх хөгжил төв 2004 онд “МОНГОЛ УЛС ДАХ ЦАГДАН ХОРИХ БАЙР” МОНИТОРИНГИЙН тайлан .АНУ-ын Азийн сан, Хүний эрх хөгжил төвөөс 2005 гаргасан. “МОНГОЛ УЛСАД ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НЬ: АСУУДАЛ БА АРГА ЗАМ” 3 дах хэвлэл зэрэг ньХЭХ төвийн номын санд хадгалагдаж байгаа.</p> <p>2. Монголын төрийн бус байгууллагуудын форумын гишүүний үүрэгт ажлаар 2011.11.2-ны өдрийн НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 9-Р хуралдаанаар Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн зориулсан ДОЛООН САРЫН НЭГЭН БА ХҮНИЙ ЭРХ тайланг бичсэн. 2015.5.5-ны өдрийн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгийн үеэр Монгол улсын Засгийн газрын хүний эрхийн нөхцөл байдлаа дээрдүүлэх</p>

<p>огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<p>чиглэлээр 2010 онд авсан үүрэг амлалтын биелэлтийг авч хэлэлцэх хуралдаанд “ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНЕВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТ” тайлан бичсэн. Эдгээр тайлангууд Нээлттэй нийгэм форумын номын санд хадгалагдаж байгаа.</p> <p>3. Нээлттэй нийгмийн хүрээлэнгийн дэмжлэг, Монголын Төрийн бус байгууллагын форумын гишүүн, Хууль хүний эрх ТББ-ын гүйцэтгэх захирал алба хашиж байхдаа 2008 онд “ДОЛООН САРЫН НЭГЭН БА ХҮНИЙ ЭРХ” мониторингийн тайланг бэлтгэн хэвлүүлсэн. Нээлттэй нийгмийн хүрээлэн болон Хууль хүний эрх төвийн номын санд хадгалагдаж байгаа.</p> <p>Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд олон удаа ярилцлагыг өгч байсан ч хэрэг болно хэмээн үзэж хадгалж байгаагүй учир баримт байхгүй байна.</p>
---	---

--- оОо ---